| 24 | 48 | "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БСШУСБХ | 1.1/. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх; | Ариун цэврийн байгууламж байхгүй сургууль цэцэрлэгийн барилгад "Нутаг консалтинг" ХХК нэг маягийн барилгын зураг төсөв хийж барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт гаргуулж батлуулсан байна. | 70% | 30% | 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй |
| | 49 | | 1.2/. төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах; | Төслийн 3-р ээлжийн Багц-1 Дадал, Батноров, Хэрлэн Өлзийт тосгоны ариун цэврийн байгууламжийн ажил 95% тай, 4-р ээлжийн Багц-2 Жаргалтхаан, Хэрлэнбаян-Улаан, Мөрөн, Баянхутаг, Галшар сумдын нийт ажлын гүйцэтгэл 85%, Багц-3 Өмнөдэлгэр Хурх тосгон Батширээт сумдын ажлын явц 80%-тай хэрэгжиж байна. | 70% | 70% | |
| | 50 | | 1.3/. төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг | Ариун цэврийн байгууламж байхгүй сургууль цэцэрлэгийн барилгад "Нутаг консалтинг" ХХК нэг маягийн барилгын зураг төсөв хийж | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох; | барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт гаргуулж батлуулан 4-р ээлжийн сумдад өргөтгөл хийгдсэн. Ариун цэврийн өрөөтэй сургууль цэцэрлэгийн барилгад засварын зураг төсвийг магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан. | | | |
| | 51 | | 1.4/. захиалагчаас тогтоосон нөхцөл, | "Нутаг консалтинг" ХХК нэг маягийн барилгын зураг төсөв болон | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу 2022 оны 4 дүгээр сард багтаан тус тус сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлэн гүйцэтгэлд хяналт тавих; | засварын ажлын зураг төсвийг хийж барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлт гаргуулж батлуулан Багц-1 ажлыг Чандмань Хангай ХХК, Багц-2 ажлыг Баатар шүтээн Уул ХХК нар 2023 онд ажлыг элүүлж, энэ онд ажлын гүйцэтгэл 88%-тай үргэлжилж байна. | | | |
| | 52 | | 1.5/. тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгох; | Тус ажлын Зохиогчийн хяналтыг "Нутаг консалтинг" ХХК, захиалагчийн хяналтыг Хэнтий аймгийн ГХБХБГазар, Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженерүүд гүйцэтгэж байна. | 100% | 100% | |
| | 53 | | 1.6/. Төсөл, хөтөлбөрийн | Үндэсний аудитын газар нь 21 аймагт хэрэгжиж буй төсөл | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх. | хөтөлбөрт санхүүгийн аудит хийдэг. Уг газрын 2024 оны аудит хийгдэх төслийн ажлын төлөвлөгөөнд уг төсөл хөтөлбөр хамрагдаагүй учир санхүүгийн аудитын хяналт шалгалт хийгдээгүй байна. | | | |
| 25 | 54 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ | 1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах; | МЭЕГазрын даргын 2024 оны 01 сарын 11-ны А/06 тоот тушаалаар Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын “Хэрлэнбаян-Улаан” отрын бүсэд нутаглаж буй 9 аймаг, нийслэлийн 16 сум дүүргийн 279 малчин өрхийн 160763 толгой малыг 5 ажлын хэсэг 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр гоц халдварт, халдварт өвчин гарах, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Үзлэгээр гоц халдварт өвчний сэжигтэй мал илрээгүй. | 100% | 100% | |
| | 55 | | 1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй | 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ныг | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох; | хүртэлх хугацаанд Бор- Өндөр сумын голомт, сэжигтэй бүсийн бог малыг дархлаажуулах ажлыг товлолт хугацаанд зохион байгуулж 6 өрхийн нийт 8107 толгой бог малыг дархлаажуулж гүйцэтгэл 98.8 хувьтай хийгдэж дууссан. Мөн 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Мөрөн сумын бог малыг хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд189 өрхийн нийт 122319 толгой бог малыг хамруулж гүйцэтгэл 99.4 хувьтай хийгдэж дууссан. Өнөөдрийн байдлаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил 18 суманд эхэлж гүйцэтгэл 70%- явагдаж байна. | | | |
| | 56 | | 1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч | Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хүрээнд нийт 4 төрлийн халдварт өвчний дархлаажуулалтад 580.0 мянган мал хамруулахад шаардлагатай вакциныг нэмэгдсэн үнээр тооцон хэрэгцээт эмийн бодис, тоног төхөөрөмж, үйлчилгээний хөлсний зардалд орон нутгийн төсөвт  нийт 690.9 сая төгрөгийг тусгуулсан. Мал | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх; | эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах, мал эмнэлгийн дуудлага үйлчилгээнд түргэн шуурхай үйлчлэхэд шаардлагатай автомашиныг 14.9 сая, 135.8 сая төгрөгөөр тус тус худалдан авч 2 техникийн бэлэн байдлыг бүрдүүлсэн. 2024 оны өвөлжилт хаваржилтын нөхцөл байдал хүндэрч ихэнх сумдууд малын тоо толгойн албан татварыг чөлөөлсөнтэй холбогдуулан одоогоор мал эмнэлгийн арга хэмжээнд төсөв тусгаж зарцуулаагүй байна. | | | |
| | 57 | | 1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах; | Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хүрээнд нийт 4 төрлийн халдварт өвчний дархлаажуулалтад 580.0 мянган мал хамруулахад шаардлагатай вакциныг нэмэгдсэн үнээр тооцон хэрэгцээт эмийн бодис, тоног төхөөрөмж, үйлчилгээний хөлсний зардалд орон нутгийн төсөвт нийт 690.9 сая төгрөгийг тусгуулсан. Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах, мал эмнэлгийн дуудлага үйлчилгээнд түргэн шуурхай үйлчлэхэд шаардлагатай автомашиныг 14.9 сая, 135.8 сая төгрөгөөр тус тус худалдан авч 2 техникийн бэлэн байдлыг бүрдүүлсэн. Хүнс, хөдөө аж, ахуйн | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/140 дугаар захирамжийн хүрээнд Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн Мал эмнэлгийн газрын нөөцөөс 18 суманд 1350 кг хлорын шохой, 570 ш халдвар хамгааллын хувцас. МЭЕГазраас 90 кг халдваргүйтгэлийн бодис, 250 ширхэг халдвар хамгааллын хувцас, УОК-ын шуурхай штабаас олгосон 4 тн хлорын шохой, аймгийн Засаг даргын А/210 тоот захирамжаар 2350 кг хлорын шохой, 5 сая төгрөгийн халдвар хамгааллын хувцас аймгийн Засаг даргын А/210 тоот захирамжаар 39.0 сая төгрөг зэрэг сумдад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцсыг хуваарилан олгож мал их хэмжээгээр хорогдсон 9 сум 1 тосгонд санхүүгийн дэмжлэг үзүүлж, мөн Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 200 ширхэг халдвар хамгааллын хувцас зэргийг тус тус сумдад олгосон. | | | |
| 26 | 58 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар | Аймгийн Ахмадын хорооны урсгал зардлын төсвийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 27 дугаар хуралдааны 08 дугаар | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | тогтоолоор 110 сая төгрөгөөр батлуулсан. Мөн ХХҮГ-н дэргэдэх Ахмадын сувилалд орон нутгийн төсвөөс 62 сая төгрөгийн үнэ бүхий 24 нэр төрлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэж, ахмад настны амарч сувилуулах орчныг бүрдүүлсэн. | | | |
| 27 | 59 | Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ | 1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг | Аймгийн хэмжээнд зуны улиралд 6 аж ахуйн нэгж сүү цуглуулах цэг ажиллуулж байна. Батширээт сумын "Биндэръяа сүү ХХК" сүү боловсруулах цех кластерын зарчмаар үйл ажиллагаа явуулж байна. ЖДҮ-н 6%-н эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлд сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр “Түмэн марс” ХХК 100.0 сая төгрөг, “Үлэмж Төгөлдөр Од” Хоршоо 100.0 сая төгрөг, нийт 200.0 сая төгрөгийн зээл дэмжигдсэн. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх | | | | |
| 28 | 60 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ | 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах; | Хар ямаатын улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газар нутагт амьдардаг 5 малчин өрхтэй газар ашиглах гурвалсан гэрээ байгуулж ажиллаж байна. | 100% | 100% | |
| 29 | 61 | Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ | 1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг | НЦҮТөв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч нь 2023 оны 1 сараас орон тоогоор дангаар ажиллаж байна. НЦҮТөв, ТХБайранд нийт 10 хүүхэд, 1 насанд хүрэгч ирснээс 7 хүүхэд, 1 насанд хүрэгч, нийт 8 хүнд зөвлөгөө, оношилгоо гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. НЦҮТөв, Түр хамгаалах байранд | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах; | онлайнаар үйлчилгээг авах нөхцөл боломжоор хангаж, онлайн төхөөрөмжийг байрлуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээгээр сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд нийт 88 хүн хандсанаас 27 хүн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар хандаж зөвлөгөө авсан. Мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургуулийн Дохионы хэлмэрчийн 2 жилийн ангид орон нутгийн төсвөөс гэрээ байгуулан сурч төгссөн дохионы хэлмэрч ажилтан орон нутагтаа дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулж төрийн байгууллагын 8 албан хаагчийг хамруулж, төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд хүртээмжтэй байдлаар үзүүлэхээр ажиллаж байна. | | | |
| | 62 | | 1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд сэтгэл зүйн хямралд өртөх, давтан хохирохоос сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах зорилгоор насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах, цахим шүүх хуралд оролцох боломжийг хангасан иж бүрэн тоног төхөөрөмжтэй өрөөг аймгийн Прокурорын газрын | 100% | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах; | зөвшөөрөлтэйгөөр ашиглаж байна. Тус өрөөнд хагас жилийн байдлаар хохирогч 5 хүүхдээс тайлбар мэдүүлэг авсан. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах, хүүхдээс мэдүүлэг авах дагнасан 2 байцаагч томилогдон ажиллаж байна. | | | |
| | 63 | | 1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх. | Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийн хүрээнд гэр бүл, нийгмийн бүхий л орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахад эцэг, эх байгууллага, аж ахуй нэгжийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх, хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтыг хэрэгжүүлэх, ажил олгогч нар ажилчдынхаа сайн аав, ээж байх нөхцөл боломжоор хангаж, гэр бүлдээ чанартай цаг гаргахад нь дэмжлэг үзүүлэхийг уриалж 11 аж ахуй нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж зөвлөмж өгч ажилласан. Аймгийн хэмжээнд 190 эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 105 байгууллага хүүхэд хамгааллын бодлого баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | | | |
| | 64 | | 1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх; | Хүүхэд хөгжлийн төвийн дэргэд 4 төрлийн дугуйланд 98 хүүхэд хамрагдаж байна. Мөн хүүхдийн хөгжлийг дэмжих зориулалтаар баригдсан "Ид шидийн орон"-ны дэргэд 5 төрлийн дугуйланд 122 хүүхэд хамрагдаж, нийт 9 төрлийн дугуйланд 220 хүүхэд хамрагдаж байна. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих зорилгоор орон нутгийн төсөвт 6.5 сая төгрөгийг тусгаж, хүүхэд хөгжлийн төвийн дэргэд "Асури" мини театрыг байгуулан бага насны хүүхэдтэй гэр бүлд хөгжлийн үйлчилгээ үзүүлж байна. | 70% | 70% | |
| | 65 | | 1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар | Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн боловсрол олгох зорилгоор урьдчилан сэргийлэх 1 аян, 1 жүжиг, 1 лекц, 5 тэмцээн, 4 нөлөөллийн ажил, 1 өдөрлөг, 1 наадам, 3 уралдааны | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах; | зохион байгуулж цахим хэлбэрээр 41.112 хүн, 15.018 хүүхэд, 7.445 эцэг, эх асран хамгаалагчийг хамруулсан. | | | |
| | 66 | | 1.2.4/. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах; | 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийгдсэн. | 100% | 70% | 6.3.2. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа 1. Арга хэмжээний хэрэгжилтийг тодорхой тайлагнах |
| | 67 | | 1.2.6/. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх. | Хүүхдийн эрхийн улсын байцаагч аймгийн хэмжээнд 1 орон тоогоор ажиллаж байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч бэлтгэх хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 2 Нийгмийн | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажилтан хамрагдсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжээ авч чадахгүй байгаа талаарх 41 хүүхдэд холбогдох 21 өргөдөл гомдлыг хүлээн авч шалган, ХЭУБ-ын 23 дүгнэлт гарган ХХҮГ-т хүргүүлж, хүүхдийн мөнгөний барилтыг хийж, хүүхдийн эрх дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн амралт эхэлж байгаатай холбогдуулан хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг илрүүлэх зорилгоор авто угаалга, хүнсний дэлгүүр, барилга, PC тоглоомын газар, худалдааны төв, халуун ус, авто засвар, талх нарын боовны цех, банш буузны үйлдвэр, караоке, ноосны үйлдвэр, бой, паб, ресторан, сүм хийд зэрэг нийт 75 аж ахуй нэгжээр хяналт шалгалтыг хийж 5 хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэн судалгаа мэдээллийн санд бүртгэж яриа таниулга хийж ажилласан. | | | |
| 30 | 68 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ | 6в/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар | 2025 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг иргэдээс PIMIS системээр 2024 оны 3-р сарын 1-с 3-р сарын 31-г дуустал авсан. Уг санал хураалтад 13 иргэн оролцож саналаа өгсөн байна. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэвтрүүлэх, Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга /С1оЬа1 1пШайуе Тог Е\|вса1 Тгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зарчмуудыг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох; | | | | |
| | 69 | | 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай | “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд зохион байгуулж буй “ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” сэдэвт дэмжих хөтөлбөртэй | 70% | 30% | 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамтран ажиллах. | хамтран аймгийн 2025 оны төсвийн төлөвлөлтийг боловсруулахаар ажиллаж байна. | | | шийдэгдээгүй |
| 31 | 70 | Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10 | 1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх; | Төрийн байгууллагуудад төрийн албанд томилогдож байгаа иргэдийг томилохдоо ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх, байгууллагын дарга албан хаагчидтай хариуцлагын гэрээг байгуулж, томилж байх чиглэлийг хүргүүлэн 2024 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан иргэнийг томилсон шийдвэр байхгүй болно. | 100% | 100% | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 32 | 71 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд | Хэнтий аймгийн төрийн байгууллагын гадаад, дотоод хаягжилт 100% үндэсний бичгээр бичигдсэн. Мөн 3 сумын 20 гаруй аж ахуйн нэгж, барилга байгууламж хос бичгээр хаягжуулан, 63 гудамж талбайн 160 орчим нэр хаягийг кирилл, монгол бичгээр хослон байршуулж, 30 орчим нэр төрлийн бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдгийг үндэсний бичгээр бичиж, хэрэглээ болгосон. Бор-Өндөр суманд зохион байгуулсан "Гандирсын ганган бичиг минy" уриан доор “Бичиг үсгийн баяр-2024” аяны хүрээнд үндэсний | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээнд дэлгэрүүлэх, сурталчлах, судлан суралцаж хэрэглээ болгох 15 төрлийн үйл ажиллагааны оролцоо хандлага, идэвх манлайлал, амжилт, үр дүнг үнэлж, Бор-Өндөр сумын ЗДТГазрын эх хэлний зөвлөл 9,015,000 төгрөг, АЗДТГазрын эх хэлний зөвлөл 4,800,000 төгрөг, Баян-Овоо, Бэрх сумын ЗДТГазрын эх хэлний зөвлөл тус бүр 1,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд нийт 14,815,000 төгрөгөөр иргэн, албан хаагч, багш, суралцагч, байгууллага, эх хэлний зөвлөл, баг хамт олон зэргийг хамарсан 200 гаруй хүнийг шагнан урамшууллаа. | | | |
| 33 | 72 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2019-05-30<br>Дугаар 2019_104 | 1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих | ЭМСайдын 2021 оны 06 сарын 15-ний өдрийн А/370 тоот тушаалын дагуу, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дэх заалтыг үндэслэн “Хүүхдэд худалдаалахыг хориглосон 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг брошур хэлбэрээр 28 ЕБС, 34 цэцэрлэгээс 150 метрт байрлах 80 худалдаа үйлчилгээний газруудад өгч зөвлөмж мэдээлэл хүргэсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын 2.2 дах | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэсэгт “Үдийн цай хөтөлбөрт хамрагддаггүй ахлах ангийнханд зориулсан эрүүл бүтээгдэхүүн, хүнсээр үйлчлэх цэгийг сургууль дээр бий болгох” гэж заасны дагуу Хэрлэн 1, Тэмүүжин ЦС, Хэрлэн 4, Хэрлэн 5-р сургууль, Хан Хэнтий цогцолбор сургуулиуд дээрх цэгийг нээж ажиллуулж байна. Уг цэгт хяналт тавин ажиллаж хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх зөвлөмжийг сургуулийн удирдлага болон түрээслэгч аж ахуйн нэгж, иргэнд 1-3 удаагийн зөвлөмж хүргүүлэн, сургууль болон түүний ойр орчмын худалдаа үйлчилгээний газруудад улирал бүр хяналт тавьж ажилласан. | | | |
| 34 | 73 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон | Аймгийн 2024 оны орон нутгийн нийт төсвийн 1.8 хувь болох 1,236.0 сая төгрөгийн хөрөнгийг батлуулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх "Гучин сая мод" хөтөлбөр 2022-2030 он дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу зарцуулж ажиллаж байна. 2024 онд аймгийн хэмжээнд 1.2 мянган мод тарьж 1.0 сая ургуулахаар төлөвлөсөн ба ойжуулалтаар 902.5 мянга, төв суурин газрын ногоон байгууламжид 190.0 мянга, | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах  Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах | хамгаалалтын ойн зурвасаар 80.0 мянга, татмын ойжуулалтаар 27.5 мянган мод тус тус тарьж уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн биомассыг нэмэгдүүлж, цөлжилтийг саарyулан, элсний нүүдлээс хамгаалах хамгаалалтын ойн зурвасууд байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, "Тэрбум мод" хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах, мод тарих, арчлах, ургуулах талаар бүх нийтэд боловсрол, мэдлэг олгох, сургагч багш нарыг чадавхжуулах, мод тарих, ургуулах ажилд идэвх санаачилгатай, үлгэр жишээ оролцсон иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж ханган ажиллаж байна. | | | |
| | 74 | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Аймаг, сумын төвийн ногоон байгууламжид хаврын тарилтаар 104.7 мянган ширхэг мод, бут сөөгийг бүх нийтээрээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотой тарьсан. Тарьсан модоо арчлах, ургуулах, хамгаалах зорилгоор 18 сумын 158 төрийн байгууллагуудыг уриалан “НЭГ БАЙГУУЛЛАГА-НЭГ ЦЭЦЭРЛЭГ” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нийт 99 цэцэрлэг, ногоон байгууламжийг хариуцуулан эзэнжүүлж, арчилгаа, усалгаа, цэвэрлэгээний ажлыг хийх хуваарийг гаргуулж, 10 хоног тутамд хяналт тавьж ажиллах сайн дурын 21 иргэнтэй гэрээ байгуулж, хяналт тавиулж ажиллаж байна. Эдгээр байгууллагууд 2030 оныг дуустал тухайн ногоон байгууламжаа хариуцаж, өөрсдийн нэр хаяг бүхий самбар байршуулж, жил бүр шинээр мод тарьж, тарьсан модоо арчилж, ургуулж, хамгаалж ажиллах юм. Хувийн хэвшлийн байгууллагуудын мөн мод тарьж энэ аянд оролцохыг, хашаа бүхий гэр хорооллын айл өрхүүдийг ч мод тарихыг тус тус уриалж “Өрх бүр ногоон төгөл”, “Өрх бүр жимсний мод” гэх мэт аянуудыг өрнүүлэн дэмжиж ажиллаж байна. | | | |
| | 75 | | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мөрөн, Цэнхэрмандал сумдад голын урсац нэмэгдүүлэх хөв цөөрмийн ажлын 2 багц бүхий тендер, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дархан суманд хөв сэргээн засах ажлын тендерийг тус тус зарлаж, гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаад байна. Төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон | 100% | 70% | 6.3.2. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, гол үр дүн нь гарч байгаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | байгууламжийн 0.7 га талбайд шинээр усалгааны дэвшилтэт технологи бүхий систем тавьж, Чингис хотод төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 5 тн багтаамжтай ус нөөцлөх савуудыг нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад байрлуулж модны усалгаа арчилгааг тогтмол зохион байгуулж байна. | | | |
| | 76 | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх | М-Си-Эс групптэй байгуулсан хамтран ажиллах санамж гэрээний хүрээнд "Хэнтий аймагт 40,0 сая мод тарьж ургуулах төсөл"-ийн техник эдийн засгийн үндэслэлийг "Энержи ресурс" ХХК-ийн санхүүжилтээр "Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл" ТББ боловсруулан батлуулж энэ онд Дадал суманд 65 га талбайд тухайн байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан  Биндэр ой сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд бэлтгэсэн 160 мянган шилмүүст модны тарьцаар тухайн ТЭЗҮ-д батлагдсан арга зүй зөвлөмж, технологийн дагуу ойжуулалт хийхээр бэлтгэл ажил хангаад байна. | 70% | 30% | 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан |
| | 77 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай | Хэрлэн суманд “Өрх бүр жимсний мод” аяныг өрнүүлж 300 өрхөд тарьц суулгацыг олгож, иргэдэд | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | мод тарих, ургуулах эерэг зөв үйлсийг уриалж, модоо тарьж арчилж ургуулсан өрхүүдээ орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, цуврал нэвтрүүлгүүд бэлтгэж иргэд, олон нийтэд түгээж байна. Мөн сум бүрт 21 сайн дурын иргэд, нөхөрлөлийн гишүүдтэй нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллах гэрээ байгуулж, мод тарьж ургуулах үйлсэд хувь нэмэр оруулах санал санаачилгыг нь дэмжиж сар бүр урамшуулал олгож ажиллаж байна. | | | |
| 35 | 78 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2022-04-05<br>Дугаар 2022_43 | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг, мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, спортын ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор 2024 оны хагас жилийн байдлаар БТСГазар нь "Мөнхийн хайрын урсгал" төрийн бус байгууллага, "Сувдан" бүжгийн клубтай тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж өглөө бүр 06:00 цагаас 07:30 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй биеийн тамирын үйлчилгээ / өглөөний | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дасгал,шугаман бүжиг, нийтийн бүжиг, бүх насныханд софт волейбол, бадминтон зэрэг төрлүүдээр чөлөөт тоглолт/ үзүүлэн ажиллаж байна. Биеийн тамирын 45 арга хэмжээ , БТТТогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт биеийн тамирын арга хэмжээнд давхардсан тоогоор 12100 иргэн хамрагдсан байна. | | | |
| 36 | 79 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 187 байгууллага Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залсан байна. | 100% | 100% | |
| | 80 | | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байх уриалгыг хэвлэл мэдээлэл болон цахим орчинд түгээн давхардсан тоогоор 100 гаруй мянган хүнд хүр ажилласан. | 100% | 30% | 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй 1. Арга хэмжээний |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажлыг тодорхойгүй, хэмжигдэхүйц бусаар тайлагнасан, бүрэн тайлагнаагүй. |
| | 81 | | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээе сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээе сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг 4 хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд уриалсан. | 100% | 100% | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 37 | 82 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай<br>2010-03-18<br>Дугаар 2010_10/09 | 1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг | 2023 онд Хэрлэн сумын 1-р багийн эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй "банкны байр"-ны орчмыг дахин төлөвлөлтөөр гүйцэтгэгч шалгарсан боловч цуцлагдсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн Газрын 212 дугаар тогтоолоор | 30% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, | баталсан барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах дүрмийн 2 дугаар хавсралтын дагуу Хэрлэн сум 1-р багт баригдсан Өгөөж Өргөө ХХК-ны 52 айлын орон сууцны барилгыг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | | | |
| | 83 | | 3. Газар хөдлөлтийн аюул, гамшиггай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тоггмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооодог байх, | Аймгийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшгийн үед иргэдийг дадлагажуулах зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар Дархан суманд гамшгаас хамгаалах Иж бүрэн сургууль, Баянхутаг суманд гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулан нийт 142 иргэн, ажилтан албан хаагчдыг хамруулан дадлага сургууль зохион байгуулсан. Мөн Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-д зааснаар 03 дугаар сарын 28-ний өдрийн 16:00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, дадлага сургууль зохион байгуулж Хэнтий аймгийн 5 түр цугларах цэгт 5000 гаруй иргэдийг цуглуулж мэдээ, | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээлэл, сургалтыг зохион байгуулж ажилласан. | | | |
| 38 | 84 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх. | Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зарцуулагдах зардал болох 3 сая төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаад байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд ахуйн хэрэглээний газыг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахгүй байх талаар аймгийн Цагдаагийн газраас зөвлөмж хүргүүлсэн. Тус гэмт хэрэг энэ онд бүртгэгдээгүй байна. | 100% | 100% | |
| 39 | 85 | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 | 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн | Чингис хотод 3000мкуб/хоног цэвэрлэх байгууламжийг 2022 оны 8 дугаар сард байнгын ашиглалтад оруулсан. Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал, Батноров сум, Бэрх тосгон/ ажлын 5 сумын ариутах татуурга, цэвэрлэх байгууламжийн ажил ашиглалтад орж Багц-2, Багц-3 ажил 85%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Чингис хотын 1,2-р багийн гэр хорооллын инженерийн шугам | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх | сүлжээний ажлын бохир усны шугам сүлжээний ажил 100% дууссан иргэд холбоход бэлэн болсон байна. | | | |
| | 86 | | 2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих | Чингис хотод 3000мкуб/хоног цэвэрлэх байгууламж, Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал, Батноров сум, Бэрх тосгон/ ажлын 5 сумын ариутах татуурга, цэвэрлэх байгууламжийн ажил ашиглалтад орсон байна. Мөн Цэвэрлэх байгууламжийн ашиглалтын жилийн үйл ажиллагааны зардлын эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Цэвэрлэх байгууламж нь бохир усыг 95% хүртэл цэвэршүүлж саарал ус болгож байна. Ногоон байгууламжийн усалгаанд ашиглах боломжийг судалж байна. | 100% | 100% | |
| 40 | 87 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2021-09-30<br>Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, | Хэрлэн сумын ЕБ-н 5 сургуулийн экоклубын 110 сурагчид мод тарих аргачлалыг зааж 100 ш агч мод тариулж, мод тарих дадлага хийлгэсэн. Дэлхийн байгаль хамгаалах сан олон улсын байгууллагатай хамтран ой бүхий сумдын экоклубын 40 орчим | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | сурагчдын дунд "Бид ойчид" арга хэмжээ зохион байгуулж, мод тарих, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ой, гол мөрөн, булаг шандны эх, түүний орчныг цэвэрлэж байгаль орчноо хамгаалах мэдлэг мэдээлэл олгож сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгууллаа. Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээг сурталчлах, олон нийтэд мэдээлэх зорилготой "Тэрбум мод Хэнтий аймаг" пэйж хуудсыг нээн ажиллуулж байна. | | | |
| 41 | 88 | Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01 | 3.4. . Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; | Хагас жилийн байдлаар 5 сумын үр тариа, төмс хүнсний ногоо, ногоон тэжээл тариалах иргэн ААНэгж нь нийт 1273.4 га атаршсан тариалангийн талбайг эргэлтэд оруулсан. Шинээр олгосон атар газар байхгүй. | 70% | 70% | |
| | 89 | | 3.8.. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн | ХАА, Байгаль экологийн чиглэлээр ажиллаж буй "Мэтагро" ХХК нь зүүн бүсэд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослуулах замаар олон улсын стандартад шаардлагад нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж, | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэхээр 130 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. | | | |
| | 90 | | 3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах | Хэнтий аймгийн тогоочдын холбоотой хамтран Хэрлэн, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумын 110 иргэнд эрүүл зохистой хоолны сургалт өдөрлөгийг зохион байгуулсан. | 100% | 100% | |
| 42 | 91 | Ашигт малтмалын тусгаи зөвшөөрлиин өнөөгиин баидал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнии тухаи 2022-11-25 Дугаар 2022_03 | 1.3 . Үндэснии аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод ниицүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгаи зөвшөөрлиив олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэи болон хяэгаарлагдмал/ зохион баигуулах тусгаи зөвшөөрлиин талбаин хэмжээг | Засгийн газрын тогтоолоор нөөцөд авч ялган тэмдэгжүүлсэн талбайд Ашигт малтмал газрын тосны газраас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэй болон хязгаарлагдмал/ зохион байгуулж гарсан шийдвэрийг орон нутагт ирүүлж байна. Аймгийн нутаг дэвсгэрт хайгуулын болон ашиглалтын 210 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр олгогдсон ба нийт нутаг дэвсгэрийн 3,6 хувийг тусгай зөвшөөрлийн талбай эзэлж байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх; | | | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 43 | 92 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2021-09-08 Дугаар 2021_281 | 3. Авто замын барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, тус үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Идэрбат нарт тус тус үүрэг болгосугай. | Батширээт сумын төвийн авто замын өргөтгөлийн ажилд ашигласан хайрга, дайрганы 0.4 га, Бархын голын төмөр бетон гүүрэнд ашигласан хайрга, дайрганы 0.2 га талбайд, Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн төв магистрал замаас Өмнөдэлгэр сум хүртэлх авто замын барилгын ажилд ашигласан хайрга, дайрганы 9 га талбай, нийт 9.6 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийлгээд байна. | 100% | 100% | |
| 44 | 93 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах | 5.1. Мэргэжлийн нэр томьёог орчуулах санал хүсэлт байгууллагуудаас ирээгүй байна. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын | 5.2 Хэнтий аймгийн Шинжлэх ухаан инновац, эх хэл хамтын ажиллагаа,"Хэнтий Монгол бичиг" талбаруудад кирилл болон үндэсний бичгээр хослон 22 төрлийн 51 гаруй мэдээ, мэдээлэл, бичиг үсгийн баярын цахим постер зэргийг нийтэлсэн ба 3 сумын дотоод мэдээллийн сонин сэтгүүл, зар сурталчилгааны мэдээлэл зэрэг нь монгол бичгийн хадмал тайлбартайгаар нийтлэгдэж, хэрэглээ болж байна. 5.3. Хэнтий аймгийн хэмжээнд төрийн 189 байгууллагын 95 байгууллага буюу 50.2 %-нь албан баримт, хэвлэмэл хуудсаа монгол бичгээр хэвлүүлсэн ба 30 гаруй хувь нь ашиглаж хэвшээд байна. Архивын газар албан бичиг баримт, баланкыг хэвлэж буйтай холбоотой сумдын салбар зөвлөлийн гишүүн эх хэлний багш нар эх бэлтгэлийг бэлтгэн ирүүлж, дэмжлэг үзүүлж байна. 5.4. Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөлийн ажлын албаны даргын 2023 оны А/38 тушаалаар баталсан төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн сургалтын хөтөлбөрийн дагуу аймгийн 18 сумын хэмжээнд 88 байгууллагын 2040 гаруй ажилтан албан хаагч монгол бичгийн анхан шатны танхимын | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | сургалтад хамрагдсан байна. Төрийн албан хаагчийн сургалтын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академи нь төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтын хичээлийг бэлтгэн нээлттэй байршуулсан бөгөөд энэхүү сургалтын 1-3 дугаар түвшний хичээлийг давхардсан тоогоор 18 сумын 3000 гаруй албан хаагч үзэж, сорил гүйцэтгэн, үнэмлэх авсан байна. 5.5. Төрийн байгууллагын хаягийг стандартын дагуу үндэсний бичгээр хослон бичих гадна хаягжилт 100%, дотоод хаягжилт 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Нэрийн хуудсаа монгол бичгээр хослон бичиж хэвлүүлсэн нийт 49 удирдлага, ажлын үнэмлэхийг үндэсний бичгээр хослон бичсэн 36 албан хаагч байна. | | | |
| 45 | 94 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314 | 2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022- | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор "Соёл, урлагийн салбарын 2024 оны соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ"-ний төлөвлөгөөг 7 зорилт 16 арга хэмжээтэйгээр төлөвлөн ажиллаж, хагас жилийн байдлаар 70 хувьтай хэрэгжиж байна. Мөн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль 2024 | 100% | 70% | 6.3.2. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ авсан, гол үр дүн нь гарч байгаа 1. Арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, | оны 05 дугаар сарын 17-ний өдөр батлагдсантай холбогдуулан соёлын эрхийн бичгээр соёлын үйлчилгээ авах боломжтой 16-18 насны хүүхдүүдэд зориулан төвийн мэргэжлийн 3 байгууллага 9, 12 жилийн сургуультай 6 сум, 2 тосгон 22 арга хэмжээ, соёлын үйлчилгээг төлөвлөж соёлын эрхийн бичиг арга хэмжээ хэрэгжихэд анхан шатны бэлтгэл ажлыг салбарын хэмжээнд ханган ажиллаж байна. Мөн Соёлын яамнаас 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай” хуулийн танилцуулгад 21 аймгийн СУГ-ын албан хаагчид хамрагдсан. | | | тайлагнаагүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | | | | |
| 46 | 95 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, | Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 11 байгууллагын 34 түрээсийн гэрээг цаасаар хүлээн авч баталгаажуулан хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн төсөвт хагас жилийн байдлаар 20,04,950 төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна. Төр иргэний нийгмийн хамтын ажиллагааны хүрээнд 2 ТББ-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, 105 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлэн ажиллаж байна. Мөн 2 ТББ-тай нийт 19 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулан хорт зуршлаасаа өөрийн хүсэлтээр ангижрах хүсэлт гаргасан 13 хүнийг эмийн эмчилгээнд, архины хор | 100% | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаарх сургалт сурталчилгаанд 4 сумын 320 иргэнийг сургалтад хамруулаад байна. Байгаль хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн байгаль хамгаалах сан, TNC-Дэй нэйче консерванси Олон Улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн байгаль орчин, Ой, Ус, Амьтан хамгаалах чиглэлээр GIZ, НҮБ-ын ХХААБ-ын stream төслүүдтэй хамтран ажиллаж тэрбум орчим төгрөгийн санхүүжилт бүхий төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээх хүрээнд ховор ан амьтдад өвс тэжээл тавьж өгөх ажлыг гүйцэтгүүлэхээр Аварга-Дэлгэрхаан нөхөрлөлүүдийн холбоо ТББ-тай гэрээ байгуулж хуваарийн дагуу зэрлэг амьтдад хаврын өвс тавих, биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулаад байна. Хөрсний үржил шимийг сайжруулах хүрээнд техникийн аргаар үлийн цагаан огтоныг устгах хүрээнд шувууны суудал 50 ш хийж суурьлуулах ажлыг Оюутчулуун шилхэнцэг ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажиллаад байна. Ховор ан | | | | |

| | | | | | | | |
| | 138 | | 3.3.. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), аймгийн Засаг дарга нарт, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт; | Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрсэн сумдын нутаг дэвсгэрт цасанд боогдсон зам харгуйг чөлөөлөх, айл өрхүүдэд хүнс, түлээ, түлш малын өвс, тэжээл хүргэх үйл ажиллагаанд 2024.02.19-ний өдрөөс Онцгой байдлын газраас давхардсан тоогоор 51 алба хаагч, 16 техник хэрэгсэлтэйгээр, Зэвсэгт хүчний анги байгууллагаас 19 алба хаагч, 7 техник, Хилийн цэргийн анги байгууллагаас 4 алба хаагч, 1 техник нийт 74 алба хаагч 24 техник хэрэгсэлтэйгээр нийт 7 суманд 5625 км газар зам гаргаж 15 хоног ажиллаж 2024.03.05-ны өдөр анги байрлаад буцсан. | 100% | 100% | |
| | 139 | | 3.8.. Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй | 2024 онд орон нутгийн төсвийн давсан орлого байгаагүй тул Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 сарын 05 өдрийн хорингуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт. | аймгийн 2024 оны төсөвт батлагдсан орлогооос гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой А/105 тоот захирамжаар малчдад Улсын онцгой комиссоос олгож буй малын тэжээл тээвэрлэхэд зориулж шатахууны зардалд 48,740,000 төгрөг, тээврийн зардалд 57,719,000 төгрөг, хөдөлмөр хамгааллалын хэрэгсэлд 2,769,000 төгрөг, Хүнсний багц 8,400,000 төгрөг нийт 117,628,00 төгрөгийг зарцуулсан. Мөн хандиваар ирсэн материалуудыг малчдад хувиарлаж ажилласан. | | | |
| 76 | 140 | Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийгдаван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_76 | 2 . Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус | Монгол улсын Засгийн газрын 279, Улсын онцгой комиссын 2024 оны 02 дугаар тушаалын дагуу 10 мянган тонн тэжээлийн улаан буудайг аймгуудад олгохоор шийдвэрлэсэн. Үүнээс Хэний аймагт хуваарилагдсан 750 тн тэжээлийн будааг Төв аймгийн Угтаал цайдам сумаас талдаа 549 км-ээс татан авч өвөлжилт хүндэрсэн төмөр зуд, цагаан зудын нөхцөлд өвөлжиж, хаваржиж байгаа сумдын малчдад үнэ төлбөргүй тараах ажлыг зохион байгуулсан. 750 тонн тэжээлийн улаан буудайг гамшгаас хамгаалах 11 алба, 23 мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг шуудайлах ажилд | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | даалгасугай. | дайчлан ажиллуулсан. Үүнд: Эхний ээлжинд 2024 оны 02 дугаар сарын 22-нд 143,82 тн, мөн хоёр дахь удаагийн тээвэрлэлтийг 02 дугаар сарын 24-нд 281.76 тн, 02 дугаар сарын 29 -нд нийт 324.42 тн тэжээлийн будааг шуудайлах ажлыг зохион байгуулж 14 сумын 5335 малчин өрхөд үнэ төлбөргүй олгож ажилласан. | | | |
| 77 | 141 | Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77 | 3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, | Тус журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан суурь болон төрөлжсөн мэдээллийн сан бүхий холбогдох мэдээллүүд тус бүрийн системүүдээр дамжин үндэсний дата төвийн серверт байрлаж байна. Хуучин систем дээр 100% үнэлэгдсэн бол шинэ системд холболтыг шилжүүлэх ажлын явц 60%. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”) | | | | |
| 78 | 142 | Тоггоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82 | 2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.) | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 06 дугаар сарын 07-ний өдрийн 08-р хуралдаанаар 2024 оны төсвийн тодотголыг хэлэлцүүлэн аймгийн 2024 оны Төсвийг 64104.5 сая төгрөгөөр батлуулсан. Үүнд: Сумдын ЗДТГ, Сумдын ИТХ, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, АЗДТГ, СХАА, ОНӨГ, БОАЖГазар зэрэг орон нутгийн төсвийн байгууллагуудын үйлчилгээний ажилласдын цалин 20%, бусад төрийн албан хаагчдын цалин 10%-иар, ОННэмэгдлийг хөдөөгийн суманд 40%, аймгийн төвд 20% байхаар тооцон нийт цалин санг 22772.4 сая төгрөгөөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% | 100% | |
| 79 | 143 | Журам батлах, журмын | 3.. Мөнгөн | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_83 | урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.) | хурлын 06 дугаар сарын 07-ний өдрийн 08-р хуралдаанаар 2024 оны төсвийн тодотголыг хэлэлцүүлэн аймгийн 2024 оны Төсвийг 64104.5 сая төгрөгөөр батлуулсан.Үүнд зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмж авах шаардлага хангасан төрийн албан хаагчдын судалгааг гаргаж Сумдын ЗДТГ, Сумдын ИТХ, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, АЗДТГ, СХАА, ОНӨГ, БОАЖГазар зэрэг байгууллагуудын 149 хүнд 1196.0 төгрөгийг олгохоор тооцон төсөвт тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | | |
| 80 | 144 | Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай<br>2024-03-06<br>Дугаар 2024_89 | 2. Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан, холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Аймгийн Засаг даргын 2024 оны А/166, А/318 захирамжуудаар дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг томилогдож, 2024 оны 4, 6 саруудад 2 удаа тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг зохион байгуулж, Аргаль 4, Халиун буга 5, Цагаан зээр 30, Агнуурын шувуу 50, тул 90, бусад загас 900 агнуулж бариулах зөвшөөрөл олгож гэрээ байгуулан хяналт тавин ажиллаж | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | | | |
| 81 | 145 | Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-04-03 Дугаар 2024_136 | 2.. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. (“Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын | 2024 онд аймгийн хэмжээнд 8 суманд 360 иргэнд 38.34 га газрын шинээр өмчлүүлэх, 16 суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1172 иргэнд 81.43 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөгдсөнөөс Засгийн газрын 2024 оны 136, 137 дугаар тогтоолын дагуу 2024 онд эзэмшүүлэх өмчлүүлэх, ашиглуулах Засгийн газрын жагсаалтаар Хэрлэн сумаас бусад сумдын иргэнд өмчлүүлэх, эзэмшүүлэх төлөвлөлтүүд жагсаалтаас хасагдсан. 2024 онд иргэнд газар эзэмшүүлэх хүсэлтийг 05 дугаар сарын 27-ны өдрөөс цахимаар авч эхэлсэн. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт, "Улсын тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт) | | | | |
| 82 | 146 | Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162 | 3 . Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч | Ерөнхий гэрээгээр байгууллагуудаас тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг хүлээн авч 2024 оны 3 дугаар улиралд Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхээр ажиллаж байна . | 70% | 30% | 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нарт даалгасугай. | | | | |
| 83 | 147 | “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 2024-04-24 Дугаар 2024_166 | 3.. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй. | “Шинэ хоршоо” хөдөлгөөний талаарх мэдээллийг 38 сургагч багш, сумдын ХАА-н тасгийн Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд 18 сум, 5 тосгоны 37,323 малчдад хүргэж ажиллалаа. Энэ нь Хэнтий аймгийн нийт хүн амын 38,6 хувь, малчдын 54,0 хувьтай уулзан мэдээ мэдээллийг хүргэсэн байна. 2685 малчдыг нэгтгэсэн 313 хоршоо байгуулагдаж, арилжааны банкаар дамжуулан 32 хоршоонд 5.3 тэрбум сая төгрөгийн зээл олгосон. | 100% | 100% | |
| 84 | 148 | Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 | 1.. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, | Шаардлагатай үед нийтлэг журмыг дагаж мөрдөж, хэрэгжүүлж ажиллана. | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2024_168 | нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай | | | | |
| 85 | 149 | Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-04-24 Дугаар 2024_173 | 1.. Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай | Хүнс, хөдөө аж, ахуйн сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн удирдамж, Аймгийн Засаг даргын 2024 оны А/140 дүгээр захирамж, Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/18 дугаар тушаалын хүрээнд Сэг зэм устгалын ажлыг 18 суманд 78 ажлын хэсэг, 63 малын эмч, 311 захиргааны албан хаагч, 1779 орон нутгаас нөхөрлөл аравтын төлөөлөл малчин, нийт 2153 хүний бүрэлдэхүүнтэй 203 суудлын авто машин, 531 ачааны автомашин, 73 ковш, 19 экскаватор, нийт 826 тээврийн хэрэгсэлтэйгээр ажилласан бөгөөд нийт 52 хоногийн хугацаанд 18 сумын 72 багийн 192 устгалын цэгт 145 тэмээ, 64176 адуу, 75156 үхэр, 502836 хонь, 288161 ямаа, 390 амьтан нийт 930864 толгой мал, амьтны сэг зэмийг булшлан 97.3%-тай хийгдэж, 191 устгалын цэгийн 81019м2 ,нийтийн эзэмшлийн | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 30290 м2,хашаа хорооны 42890м2,өтөг бууцны 25096 м2,худаг уст цэгийн 5186 м2, бэлчээрийн 216238 м2, агуулах зоорийн 2900 м2 , нийт 340345 м2 талбайд 2 кг трипле кан,21 кг хайкоф,40 кг ханкон, 313,1 кг суперкилл, 3410 кг хлорын шохой, нийт 3562,4 кг халдваргүйтгэлийн бодисоор халдваргүйжүүлэлт хийсэн. 850 ш халдвар хамгааллын иж бүрэн хувцас хэрэглэсэн. | | | |
| | 150 | | 2.. Малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, иргэд, малчидтай орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан байгуулах гэрээт ажлын хөлсийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохих | Аймгийн Засаг даргын А/210 тоот захирамжаар 2350 кг хлорын шохой, 5 сая төгрөгийн халдвар хамгааллын хувцас , 39.0 сая төгрөгөөр сумдад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцсыг хуваарилан олгож мал их хэмжээгээр хорогдсон 9 сум 1 тосгонд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 200 ширхэг халдвар хамгааллын хувцас зэргийг тус тус сумдад олгосон. Сэг зэм устгалын ажлыг 18 суманд 78 ажлын хэсэг, 63 малын эмч, 311 захиргааны албан хаагч, 1779 орон нутгаас нөхөрлөл аравтын төлөөлөл малчин, нийт 2153 хүний бүрэлдэхүүнтэй 203 суудлын авто машин, 531 ачааны автомашин, 73 ковш, 19 экскаватор, нийт 826 тээврийн хэрэгсэлтэйгээр | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | журмын дагуу гаргахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус даалгасугай | ажилласан бөгөөд нийт 52 хоногийн хугацаанд ажилласан. | | | |
| 86 | 151 | Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187 | 4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний | Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрын асуудлын хүрээнд  Баян-Адарга, Баянмөнх, Дадал, Батноров, Норовлин, Хэрлэн, Баянхутаг сумдад 62 нэгж талбарт 308.9 га газрыг олгохоор төлөвлөн батлуулж, Дадал сумын төсөл сонгон шалгаруулалтыг зарласан. Мөн Биндэр, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдад шинээр байгуулагдсан хоршооны газар авах саналуудыг нэгтгэн  2024 оны ГЗБ-ын төлөвлөгөөнд тодотгол оруулахаар цахим системд төлөвлөөд байна. Бусад сумдад хоршоо байгуулагдах шатандаа явж байна. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай | | | | |
| 87 | 152 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай<br>2024-05-08<br>Дугаар 2024_196 | 3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих журмын төсөлд санал хүргүүлж ажилласан ба хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем-ийг ашиглах эрх үүсээгүй байна.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | 30% | 0% | 6.3.4. "хэрэгжээгүй"- тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй |
| 88 | 153 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай | 2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн авто замын | Авто замын засвар, бүтээн байгуулалтын ажлуудад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг дээд | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024-05-22<br>Дугаар 2024_228 | засварын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус даалгасугай | шатны байгууллагын шийдвэрийн дагуу хууль тогтоомжид нийцүүлж холбогдох шийдвэрүүдийг гаргаж, хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, тогтмол хяналт тавьж ажиллаж байна. | | | |
| | 154 | | 3.. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу хяналт тавьж, ажиллаж байна. Түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдол гараагүй байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус үүрэг болгосугай | | | | |
| 89 | 155 | Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай 2024-05-29 | 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: | 30% | 0% | 6.3.4. "хэрэгжээгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2024_239 | Б.Бат-Эрдэнэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай() | Урт хугацааны туршид хэрэгжих | | | бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 90 | 156 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан  5 зорилтын хүрээнд хийгдэх 26 арга хэмжээнд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд Боловсролын үйлчилгээнд хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн судалгааг шинэчилж, сургууль цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх асран хамгаалагч нарт асаргаа сувилгаа, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн технологи, харилцаа холбооны үйлчилгээний саадгүй байдалд үнэлгээ хийж, мэдээллийг саадгүй, хүртээмжтэй авах нөхцөл боломжийг бүрдүүлж орон нутгийн телевизүүдийн хөтөлбөрүүдийг хадмал орчуулгатайгаар хүргэх ажлууд төлөвлөгөөний дагуу | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хийгдэж байна. Мөн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, нийт 56 төрийн болон ААНБ-уудад үнэлгээ хийж хүртээмжийг сайжрууллаа. | | | |
| 91 | 157 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл<br>2022-05-11<br>Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны | 2024 оны энхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 7449 иргэний хүсэлтээр тоон гарыг үсэг олгоод байна. Үүнээс иргэний үнэмлэхэд-3641, мобайл апп-д 3808 тоон гарын үсэг олгосон. тоон гарын үсэг олгож эхэлснээс хойш нийт 40072 иргэнд тоон гарын үсэг олгосон бөгөөд олговол зохих иргэдийн 73,5% олгосон байна. Цахим үйлчилгээ 24/7 булан ажиллуулж эхэлсэн бөгөөд улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 521 тоон гарын үсэг олгосон байна. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | | | | |
| 92 | 158 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33 | XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай | 1.1.-1.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилтын хүрээнд хийгдэх 26 арга хэмжээнд хяналт тавьж ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтвортой ажлын байраар хангаж байгаа 20 төрийн байгууллагаас 16 төрийн байгууллагад 66 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байгаа бөгөөд ХБ-тэй иргэн ажиллуулдаггүй 4 байгууллагад | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг | зөвлөмж хүргүүлэн ажилласан. 9 сумын 36 байгууллага гадна талын налуу шат, хараан бэрхшээлтэй хүний хөтөч зам тохижилт хийсэн, дотор талд нойлын өрөөний бариул, гарц тэмдэг, тэмдэглэлээ, үүдний угталтын хэсгийг стандартад нийцүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй болгосон байна. Дохионы хэлмэрч бэлтгэх сургалтад нийт 9 төрийн албан хаагч хамрагдаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнийг түр ажлыг байраар хангаж 2,160,000 төгрөгийн цалин хөлсийг олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2024 онд 49 хөгжлийн бэрхшээлтэй иргэн төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг өгсөн бөгөөд сонгон шалгаруулалтын шатандаа явж байна. 1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг үйл ажиллагааг эрчимжүүлж орон нутгийн төсвөөс 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж сумдад явуулын хурал зохион байгуулж нийт 14 сумын хөгжлийн бэрхшээлтэй 108 хүүхдийг хамруулсан. Мөн 108 эцэг эх асран хамгаалагчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрчимжүүлэх;<br>1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах. | эхчүүдийн холбоотой хамтран "Хүүхэд бүхэн жаргалтай байг" сэдвийн доор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хэрхэн зөв харьцах, нийгэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн талаар чиглэл сургалт, уналт таталтын хуанлийг тогтмол хөтөлж байх зөвлөмж хүргүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан. | | | |
| | 159 | | XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав:<br>4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн | 4.2 Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс эхлэн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүүхэд болон иргэний тэтгэвэр тэтгэмж 10 хувиар нэмэгдсэн бөгөөд уг өөрчлөлтөөс хойш байнгын асаргаанд 16 хүүхэд шинээр бүртгэгдсэн. 4.5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, | 70% | 30% | 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй 1. Арга хэмжээний хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний | хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлээр хөдөлмөр эрхлэх эцэг эхчүүдийг дэмжиж, сургалт явуулж байгаа бөгөөд сургалтад хамрагдсан эцэг эхчүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах худалдааны лангууг нэг цэгийн үйлчилгээнд нээж үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. 4.9 Нийгмийн халамжийн чиглэлээр сэргээн засах тусламж үйлчилгээг Оточ Гурван-Эрдэнэ, Билэг барамид, Чинбаясгалангуй ХХК-ууд гэрээ байгуулан үйл ажиллагаа эхлүүлэн явуулж байна. Чинбаясгалангуй ХХК нь зорилтот бүлгүүдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлж байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо байнгын асаргаа шаардлагатай 3 хүүхдийг нийгмийн болон эрүүл мэнд, сэргээн засах үйлчилгээнд хамруулан ажиллахад байраар ханган дэмжлэг үзүүлж байна. 4.10 Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа шаардлагатай бага орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах талаарх судалгаанд 139 хүн материалаа ирүүлээд байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;<br>4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.5. хөгжлийн бэрхшээлтэй | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | С.Энхболд нарт;<br>4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | | | |
| 93 | 160 | 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34 | XII.10. . Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн | 1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажил, ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг хууль бусаар зогсоохгүй байх, Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.4, | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгав: 1. Геологийн салбарыг тэргүүн ээлжид хөгжүүлэх стратегийн бодлогыг баримталж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг төрийн удирдлагаар хангаж хот, суурин газар, бүс нутгийн хэмжээнд геоэкологи, газрын доорх ус, газар хөдлөл, хөрсний гулсалтын геологи орчинг тодорхойлох, эрдэс баялгийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатамжтай орчинг бүрдүүлэх, олборлох салбарыг ашигт | 16.1, 16.5-д заасны дагуу саад учруулахгүй, ажиллах боломжоор хангаж ажиллахыг бүх сумдын Засаг дарга нарт чиглэл болгосон. 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу тухайн судалгааны ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг аймгийн Засаг даргын сумдын Засаг даргатай байгуулсан “Төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх гэрээ”-нд тусгаж батлуулсан. Төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгчээс хүсэлт гаргаж, хамтран ажилласан тохиолдол, хийгдэж буй геологийн судалгааны ажил одоогоор байхгүй байна. 3. Цэнхэрмандал сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Монголламбер” ХХК-ны 2024 оны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар, хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Учралтномт констракшн”-ы 2023 оны нөхөн сэргээлтийн ажлын талаар болон өмнөх жилүүдэд иргэдийн дунд бий болсон буруу, ташаа, үндэслэлгүй мэдээллийг залруулах, хөрөнгө оруулагчдын нийгэмд болон орон нутгийн хөгжилд үзүүлж буй эдийн засгийн үр нөлөөг таниулах танилцуулга мэдээллийг сумын ИТХ-ын дарга, | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | малтмалын найдвартай нөөцөөр хангах зорилгоор улсын төсвийн санхүүжилтээр өөрийн аймгийн нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;  2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу тухайн судалгааны ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;  3. Аймаг, сумын Засаг даргын тамгын газраас төсөл хэрэгжүүлэгч тухайн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа судалгааны ажлын зорилго, үр дүнгийн талаар орон нутгийн иргэдэд таниулах, сурталчлах арга | төлөөлөгч нарт болон Хужхан багийн Засаг дарга, иргэдийн нийтийн хуралд тус тус танилцуулсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээг жил тутам зохион байгуулж байх. | | | | |
| 94 | 161 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 | XY.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд | Аймгийн хэмжээнд хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж, төрийн албан хаагчдыг эрт илрүүлэг үзлэгт бүрэн хамруулах зорилгоор аймгийн төвийн бүх төрийн байгууллагуудын албан хаагчдыг хуваарийн дагуу Нэгдсэн эмнэлэг болон Сити Мед эмнэлгийн үзлэгт тасралтгүй хамруулж байна. Хагас жилийн байдлаар нийт 42 байгууллагын 598 төрийн албан хаагчдыг хамруулсан. Мөн аймгийн ажил олгогч эздийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхимд албан хүсэлтийг хүргүүлж, ажилчдыг хамруулах ажлыг зохион байгуулж байна. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | | | | |
| 95 | 162 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | Х.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим бүртгэлийн системд төрийн өмчийн 27 сургууль, 34 цэцэрлэг шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу бүрэн үнэлж бүртгэсэн. 2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр баригдах өргөтгөл, барилгатай холбоотой 2 сургууль, 1 цэцэрлэгийн газарт өөрчлөлт ороод байгаа ба газраа баталгаажуулж | 100% | 70% | 6.3.2. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ авсан, гол үр дүн нь гарч байгаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | эзэмшилдээ авах 2 удаагийн зөвлөмж чиглэл өгч ажилласан. | | | |
| 96 | 163 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын | Төрийн байгууллагуудын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг 100% бүрдүүлсэн ба аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллагууд албан бичиг солилцооны дундын систем болох ERP, ABLE программ ашиглаж байгууллага хооронд албан бичгээ тогтмол цахимаар солилцон ажиллаж байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | | | | |
| 97 | 164 | 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4 | VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2024 онд 5 удаагийн тогтоол батлуулж Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 37 байгууллагын акталсан 86 ширхэг, шилжүүлсэн 8, 14 тээврийн хэрэгслийг худалдах ажлыг зохион байгуулж ажилласан. | 100% | 100% | |
| 98 | 165 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар | XIY.1.3. Төрийн байгууллагууд болон | Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газраас өмнөх онд 10 | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 | зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | төрлийн судалгааны мэдээллийг судалгааны сан нэгдсэн систем /https://sudalgaa.gov.mn/-д оруулсан. 2024 онд Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажил байхгүй. | | | |
| 99 | 166 | 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10 | XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд | 2024 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд нэг суманд бог малын мялзан, 8 суманд хонины цэцэг өвчин тус тус оношлогдож, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг голомт, сэжигтэй бүсийн 8107 бог мал, хонины цэцэг өвчний яаралтай | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | дархлаажуулалтад 189 өрхийн 122319 толгой малыг тус тус хамруулж өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 210.7 мян толгой үхэр хамруулж, гүйцэтгэл 64.8 хувьтай үргэлжилж байна. | | | |
| 100 | 167 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | Аймгийн хэмжээнд Жендерийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Жендерийн үндэсний хороотой хамтран аймгийн төвийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдийн төлөөллүүдэд 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр “Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого” /2022-2031/, зохистой хөдөлмөр эрхлэлт зэрэг сэдвээр холбогдох мэдээ мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулаад байна. | 70% | 70% | |
| | 168 | | XII.2.1. Хүн амыг | Хүн амыг өвчнөөс урьдчилан | 30% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хамрагдалт хагас жилийн байдлаар 30898 буюу 38.9% байна. Нийт хамрагдсан иргэдийн 20856 буюу 67.5%-д нь өвчлөл илэрсэн бөгөөд 0-17 насны хүүхдүүдийн дунд амны хөндийн өвчлөл, 18-аас дээш насны иргэдэд хоол боловсруулах замын эмгэг тэр дундаа ходоодны улайлт, үрэвсэл, шархлаа, элэгний вирусийн халдвар, элэгний өөхжилц зэрэг өвчин зонхилон тохиолдож байна. Мөн ходоод, улаан хоолойн дурангийн ачааллыг бууруулах, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Сити Мед" эмнэлэгтэй хамтарсан ажиллах гэрээ байгуулсан.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | | | |
| 101 | 169 | 2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар | IV.2. Нийслэл Улаанбаатар хот, | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Улсын хэмжээнд 2024 онд | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13 | аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" 136 дугаар тогтоол, "Монгол Улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай" 137 дугаар тогтоолоор сумдын ИТХ-аар батлагдсан төлөвлөгөөнөөс Дадал, Хэрлэн сумаас бусад 16 сумын суурьшлын бүс дэх төлөвлөлтүүд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй гэсэн шалтгаанаар жагсаалтаас хасагдсан. Засгийн газрын 136 дугаар тогтоолд аймгийн хэмжээнд 1384 нэгж талбарт 3322,38 га газрын эзэмшүүлэх ашиглуулахаар тусгагдаж, хууль тогтоомж болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хамгаалалт, хязгаарлалтын бүс зөрчсөн 893 нэгж талбар буюу 255,37 га газар жагсаалтаас хасагдсан. Засгийн газрын 137 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд Хэрлэн сум, Бэрх тосгонд 20 иргэнд 1,55 га газрыг өмчлүүлэхээр батлагдаж, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөөгүй сумдын 373 нэгж талбарын 39,45 га газар жагсаалтаас хасагдсан. Хууль тогтоомж зөрчсөн зөрчил гараагүй болно. Цаашид Хотын хөгжлийн | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | ерөнхий төлөвлөгөө хийлгэх зардлыг төсөвт суулган төлөвлөгөө хийлгэх талаар сумдад чиглэл хүргүүлсэн. 2024 онд иргэнд газар эзэмшүүлэх хүсэлтийг 05 дугаар сарын 27-ны өдрөөс цахимаар авч эхэлсэн. | | | |
| 102 | 170 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл<br>2023-04-19<br>Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмж ирээгүй болно. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нарт тус тус үүрэг болгов | | | | |
| 103 | 171 | 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл<br>2023-04-26<br>Дугаар 2023_18 | XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/189 тоот захирамжаар Онцгой байдлын газраас Баян-Адарга, Биндэр, Дадал, Галшар, Дэлгэрхаан, Өмнөдэлгэр, Норовлин сумдад Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх шуурхай бүлэг 23 хоног үүргэг гүйцэтгэсэн. Бүлгүүд үүрэг гүйцэтгэх хугацаанд 6 удаагийн ой, хээрийн гал түймрийн дуудлагаар цаг алдалгүй хурдан шуурхай ажиллаж хохирол багатай бүрэн унтрааж ажилласан. Дээрх сумдын төрийн болон хувийн хэвшлийн 173 ажилтан алба хаагч болон 793 өрхийн 1598 иргэнд ой, хээрийн гал түймэр болон Объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулан 1352 санамж хуудсыг тараан ажиллаж байна.<br>2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага Өндөрхаан телевиз, Аруухан сайт болон Онцгой байдлын газрын цахим пэйж хаяг аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хаягаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангах зорилгоор | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Шторк-2, Мэдээлэл ярилцлага-4, урьдчилан сэргийлэх постер-14, хийж цахим хаягуудаар урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулан ажилласан. | | | |
